



**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 01

Тавантолгой

Компанийн 2023 оны үйл ажиллагааны
болон санхүүгийн тайланг танилцуулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.13 дахь заалт, Тооллогын комиссын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн урьдчилсан тайланг танилцуулсаныг тэмдэглэсүгүй.
2. Компанийн үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсүгэй.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр гаргасан санал дүгнэлтийг 2024 оны үйл ажиллагааны бодлого шийдвэртээ тусгаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА  Г.ЦОГ-ӨРНӨХ





**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 02

Тавантолгой

“Тавантолгой” ХК-ийн 2023 оны үйл
ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх
Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.9 дэх заалт, Тооллогын комиссын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг цаашид бодлого шийдвэртээ тусгаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захиралд нарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ЦОГ-ӨРНӨХ



**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 03

Тавантолгой

Компанийн 2022 оны ногдол ашгийг хуваарилан тараасан тухай
мэдээлэл болон 2023 оны цэвэр ашгаас ногдол
ашиг хуваарилах шийдвэрийг танилцуулах тухай

Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 46.2, 46.15 дахь хэсэг, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйл 6.14.13 дахь заалт, Тооллогын комиссын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2022 оны ногдол ашиг олгосон тайлан, 2023 оны жилийн эцсийн аудитаар баталгаажуулаагүй санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас ногдол ашиг болгон хуваарилах талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 03 дугаар тогтоолыг дэмжсүгэй.
2. Санхүүгийн тайланг аудитаар дахин баталгаажсаны дараа ногдол ашиг хуваарилах эцсийн тооцоог хийж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.
3. 2023 оны ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд бүрэн олгох ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ЦОГ-ӨРНӨХ



**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 04

Тавантолгой

**Компанийн дүрэмд өөрчлөлт
оруулах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 13 дугаар бүлгийн 2 дахь заалт, Тооллогын комиссын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2012 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Тавантолгойн хувьцаат компанийн дүрэм”-д дор дурдсанаар өөрчлөлт оруулсугай.

7 дугаар бүлгийн 1-д “Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.” гэснийг “Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна. Төлөөлөн удирдах зөвлөл нь тамга, тэмдэг, хэвлэмэл хуудастай байна” гэж,

10 дугаар бүлгийн 1-д “ТУЗ, Гүйцэтгэх захирал, дэд захирал, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий менежер, эдийн засагч, маркшейдер, технологи инженер, механик инженер зэрэг албан тушаалтныг компанийн эрх бүхий албан тушаалтан гэнэ” гэснийг “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, Гүйцэтгэх захирал, газрын захирал, ерөнхий нягтлан бодогч нарыг эрх бүхий албан тушаалтан гэнэ” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Өөрчлөн найруулсан компанийн дүрмийг хуульд заасан хугацаанд багтаан эрх бүхий байгууллагад бүртгүүлэх ажлыг Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад тус тус даалгасугай.

3. Өөрчлөн найруулсан компанийн дүрмийг эрх бүхий байгууллагад бүртгэсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ЦОГ-ӨРНӨХ



**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 05

Тавантолгой

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2024 оны төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15 дах заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.12, 6.14.13 дахь заалт, Тооллогын комиссын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төсвийг хавсралтаар баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Цалин урамшууллын хороонд даалгасугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх удирдлагад зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ЦОГ-ӨРНӨХ

“Тавантолгой” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн
ээлжит хурлын 05 дугаар тогтоолын
Хавсралт



Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны төсөв

| № | Зардлын нэр | Хэм.нэгж | Зардал |
|---|--|----------|-------------|
| 1 | Үндсэн цалин хөлс | мян.төг | 675,600.0 |
| 2 | НДШимтгэл | мян.төг | 97,962.0 |
| 3 | Албан томилолт | мян.төг | 34,412.0 |
| 4 | Тээвэр, шатахууны зардал | мян.төг | 141,000.0 |
| 5 | Бичиг хэргийн зардал | мян.төг | 10,000.0 |
| 6 | Хурлын зардал | мян.төг | 55,000.0 |
| 7 | Сургалт, зөвлөх үйлчилгээний зардал | мян.төг | 50,000.0 |
| | Нийт зардал | | 1,063,974.0 |



**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 06

Тавантолгой

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйл 6.14.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Тооллогын комиссын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн, хараат бус гишүүдийг санал хураах кумулятив аргаар дараах бүрэлдэхүүнтэй сонгосугай. Үүнд:

- 1.1 Лхачингийн Батчулуун /ердийн гишүүн/
- 1.2 Чимэдийн Эрдэнэдорж /ердийн гишүүн/
- 1.3 Шоовдорын Баянбат /ердийн гишүүн/
- 1.4 Ганбаатарын Ганчимэг /ердийн гишүүн/
- 1.5 Сүрэнхүүгийн Мятавдорж /ердийн гишүүн/
- 1.6 Цэнд-Аюушийн Цэнгэлбаяр /ердийн гишүүн/
- 1.7 Галсандоржийн Цог-Өрнөх / хараат бус гишүүн/
- 1.8 Доржпаламын Нацагдорж / хараат бус гишүүн/
- 1.9 Эрдэнийн Бямбажав/ хараат бус гишүүн/

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбоотойгоор Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 дүгээр сарны 21-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ЦОГ-ӨРНӨХ



**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 07

Тавантолгой

Үр дүнгийн урамшуулал олгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15 дахь заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйл 6.14.12, 6.14.13 дахь заалт, “Тавантолгой” ХК-ийн Үйлдвэрчний эвлэлийн хорооны санал, Тооллогын комиссын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, ашигт ажиллагааны түвшинг харгалзан үзэж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үр дүнгийн урамшуулал болгон тухайн оны давсан цэвэр ашгийн 1 /нэг/ хүртэлх хувиар тооцон олгохыг зөвшөөрсүгэй.

2. Үр дүнгийн урамшуулал олгох, түүнтэй холбогдон гарах зардлыг холбогдох зардлаас гаргахыг Гүйцэтгэх удирдлагад зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ЦОГ-ӨРНӨХ